



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/94

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн “Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай” 46 дугаар зарлигийн 3, Засгийн газрын 2013 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол хэл бичгийн боловсролыг сайжруулах арга хэмжээний тухай” 37 дугаар тогтоолын 5, Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 96 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III” хөтөлбөрийн 3.1.13, Засгийн газрын 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 325 дугаар тогтоолын 2.”д” дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 90 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөөнд тусгасан төрийн бүх шатны байгууллага аж ахуйн нэгж болон гудамж, зам, талбайг “Монгол-Крилл бичиг”-ээр хаягжуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Т.Ариунболд (аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Г.Түвшинтөр (аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын ерөнхий архитекторч)

Гишүүд: Э.Батаа (аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын Сургалт судалгаа арга зүйн хэлтсийн дарга)

С.Цэдэнсодном (Арвайхээр хотын захирагчийн албаны ерөнхий менежер)

Ц.Удвал (аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирлагын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Мөнхбат (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Сумдын Засаг дарга нар

2. Төрийн бүх шатны байгууллага, аж ахуйн нэгж болон гудамж, зам, талбайг “Монгол-Крилл бичиг”-ээр хаягжуулах ажлыг 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө зохион байгуулж, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100206

D:My Doc. Zahiramj. Zasag darga